

Кино урлагийг дэмжих сангийн 2023 оны үйл ажиллагааны хэрэгжилт

Соёлын сайдын 2023 оны А/168 дугаартай “Хувь хэмжээний тушаал”-ын хэрэгжилтийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангаас 2023 онд санхүүжүүлэх 1, 2 дугаар ээлжийн төслийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг 2023 оны 05 дугаар сарын 31-нээс 06 дугаар сарын 30, 2023 оны 08 дугаар сарын 31-нээс 09 дүгээр сарын 30-ний өдрийн хооронд тус тус 2 ээлжээр төсөл, арга хэмжээний мэдүүлгийг системээр хүлээн авсан бөгөөд I ээлжийн 44, II ээлжийн 43 нийт 87 төсөл бүртгэгдсэн байна.

“Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкиг сонгон шалгаруулах, хөнгөлөлтэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих” журмын 5.1-д Зөвлөл санхүүжилт хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш 45 хоногт багтаан хуралдаж хүсэлтийг хэлэлцэн төсөл, арга хэмжээг үнэлэн сонгон шалгаруулж, санал, дүгнэлт гаргаж соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ гэж заасны дагуу сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, сонгон шалгаруулалтыг гүйцэтгэж I ээлжийн нийт 10 төсөл арга хэмжээг дэмжихээр шийдвэрлэн зөвлөлийн гишүүдийн дүгнэлт бүхий Зөвлөлийн 2023 оны 9 дүгээр сарын 14-ны өдрийн №37 тогтоол, II ээлжийн нийт 6 төсөл, арга хэмжээг дэмжих саналыг Зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн №45 тогтоол, холбогдох хурлын тэмдэглэлийг тус тус Соёлын сайдад хүргүүлсэн.

2023 оны I ээлжийн шалгарсан 10 төсөлд Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Зардал батлах тухай” А/402 дугаар тушаалаар Кино урлагийг дэмжих сангаас 2023 онд нийт 10 төсөл, арга хэмжээнд 1,256,848,000.0 (нэг тэрбум хоёр зуун тавин зургаан сая найман зуун дөчин найман мянга) төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүжилт, II ээлжийн шалгарсан 6 төсөлд Соёлын сайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Зардал батлах тухай” А/65 дугаар тушаалаар Кино урлагийг дэмжих сангаас 2024 онд нийт 6 төсөл, арга хэмжээнд 1,012,645,700.0 (нэг тэрбум арван хоёр сая зургаан зуун дөчин таван мянга долоон зуун) төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүжилт тус тус олгохоор шийдвэрлэсэн.

“Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкиг сонгон шалгаруулах, хөнгөлөлтэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих” журмын 6.2-д заасны дагуу Кино урлагийн зөвлөл нь эцсийн шатны шалгаруулалтаар шалгарсан I ээлжийн 10, II ээлжийн 6 төсөл, арга хэмжээний төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй КУДС-ийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэх I ээлжийн гэрээг 2023.10.20 – 2023.11.02, II ээлжийн гэрээг 2024.03.25 – 2024.03.27 хооронд тус тус байгуулж, Кино урлагийн зөвлөлийн даргын 2023 оны 11 сарын 13-ний өдрийн А/25, 2024 оны 04 сарын 02-ны өдрийн А/22 “Зардал гаргах тушаал”-аар төсөл тус бүрд олговол зохих санхүүжилтийн 80 хувийг урьдчилан олгосон.

Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлсэн I ээлжийн төслийн мэдээлэл

№	Төслийн нэр, төрөл	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага иргэн	МҮКУЗ-ийн санал дүгнэлт, санхүүжүүлэх хэмжээ (төгрөгөөр)	Санхүүжилт авсан төслийн үе шат
Нэг. Кино бүтээх төсөл				
1.1.	“Бэрх шагай” хүүхдийн уран сайхны кино	Чулуундорж БИЛГҮҮН /ШЗ84052417/	70,000,000	<ul style="list-style-type: none"> - Дуу, дүрсний эвлүүлэг, найруулга хийх үе шат - Олон нийтэд түгээх үе шат
1.2.	“Нүүдэлчдийн музей” баримтат кино	Монголын Үндэсний музей /Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар/	51,100,000	Зураг авалтын үе шат
1.3.	“Гэрэлт бөмбөлөг” уран сайхны кино	Дамдинсүрэн САЙХАНБИЛЭГ /ЛН80082501/	68,600,000	<ul style="list-style-type: none"> - Дуу, дүрсний эвлүүлэг, найруулга хийх үе шат - Олон нийтэд түгээх үе шат
1.4.	“Хүннү, түүхээс өмнөх түүх” баримтат кино	“Монголын өвөг түүх судлалын нийгэмлэг” Холбоо /НҮТББ/	126,000,000	Зураг авалтын үе шат
1.5.	“Улсаа урлахуй” баримтат кино	“Мандала фильмс” ХХК	150,500,000	Зураг авалт үе шат
1.6.	“Алтаргана” уран сайхны кино	“Улаанбаатар телевиз” ХХК	75,000,000	<ul style="list-style-type: none"> - Дуу, дүрсний эвлүүлэг, найруулга хийх үе шат - Олон нийтэд түгээх үе шат
Хоёр. Олон Улсын кино наадам зохион байгуулах				
2.1.	"HUMAN RIGHTS 75" Монгол дахь Хүний эрхийн олон улсын анхдугаар кино наадам	“Кино гүүр хөгжлийн холбоо” Холбоо /НҮТББ/	445,648,000	<ul style="list-style-type: none"> - Кино наадмын бэлтгэл ажлыг хангах үе шат - Олон улсын кино наадам зохион байгуулах үе шат

2.2.	"Улаанбаатар" олон улсын XV кино наадам	"Монголын урлагийн зөвлөл төв" Холбоо /НҮТББ/	120,000,000	Кино наадмын бэлтгэл ажлыг хангах үе шат
Гурав. Кино урлагийн уран бүтээлч ажилтныг хөгжүүлэх сургалт				
3.1.	Компьютер график, эвлүүлэг, өнгө шүүлтийн сургалт	"Рэйдхируу" ХХК	50,000,000	Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах үе шат
3.2.	Киноны дуу авиа, хөгжмийн найруулагч нарыг мэргэшүүлэх, чадварыг бэхжүүлэх	"Саунд имежинг глобал" ХХК	100,000,000	Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах үе шат
НИЙТ 1,256,848,000.0				

Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлсэн II ээлжийн төслийн мэдээлэл

№	Төслийн нэр, төрөл	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага иргэн	МҮКУЗ-ийн санал дүгнэлт, санхүүжүүлэх хэмжээ (төгрөгөөр)	Санхүүжилт авсан төслийн үе шат
Нэг. Кино бүтээх төсөл				
1.1.	"Би ганцаараа биш" уран сайхны кино	"Эй Ти Ти бродерс дэма" ХХК	175,542,500	<ul style="list-style-type: none"> - Дуу, дүрсний эвлүүлэг, найруулга хийх үе шат - Олон нийтэд түгээх үе шат
1.2.	"Сум" уран сайхны кино	Сахъяа БЯМБА /ХЖ62122977/	350,000,000	<ul style="list-style-type: none"> - Зураг авалтын бэлтгэл хангах үе шат - Зураг авалтын үе шат
1.3.	"Бодит тусгал" уран сайхны кино	"Монгол стант" Холбоо /НҮТББ/	300,000,000	<ul style="list-style-type: none"> - Дуу, дүрсний эвлүүлэг, найруулга

				хийх үе шат - Олон нийтэд түгээх үе шат
1.4.	“Эх” уран сайхны кино	“Хувьсал продакшн” ХХК	50,000,000	- Дуу, дүрсний эвлүүлэг, найруулга хийх үе шат - Олон нийтэд түгээх үе шат
Хоёр. Олон Улсын кино наадам зохион байгуулах				
2.1.	“Алтан Өргөө” олон улсын наадам 2024 зохион байгуулах төсөл	Шагдарсүрэн ИХБАЯР /УЮ88030852/	100,000,000	Кино наадмын үйл ажиллагааг зохион байгуулах үе шат
Гурав. Кино урлагийн уран бүтээлч ажилтныг хөгжүүлэх сургалт				
3.1.	Film lighting & Camera workshop 2024 сургалт зохион байгуулах төсөл	“Синеплас” ХХК	37,103,200	Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах үе шат
НИЙТ			1,012,645,700.0	